“МОДОН БАРИЛГЫН ЗУРАГ, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨЛТ. ЕРӨНХИЙ ДҮРЭМ” /БД/-ИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Орон сууц нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай салшгүй холбоотой юм.

Модыг боловсруулахад бага эрчим хүч шаардагддаг ба эсийн хөндий бүхий бүтэцтэй маш сайн дулаан тусгаарлагч болдог тул эрчим хүчний хэмнэлттэй байгаль орчинд ээлтэй ЭКО бүтээгдэхүүн юм.

Модон бүтээцтэй барилгыг барих технологид суралцахад хялбар, ашиглагдах материалууд нь бат бэх, хөнгөн, ашиглахад хялбар, барилга барих хугацаа бага шаарддагаас гадна барилгын уян хатан, газар хөдлөлт тэсвэрлэх чадвар өндөр байдаг.

Манай оронд модон бүтээцийг сүүлийн жилүүдэд өргөнөөр хэрэглэн дэлхийд мөрдөгдөж байгаа барилгын системийн ерөнхий төлөв байдалтай уялдуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Канадын орчин үеийн модон бүтээцтэй барилгыг ихээр барьж байна. Мод, модон бүтээцээр архитетурын төрөл бүрийн шийдэлтэйгээр өндөр барилга барих бүрэн боломжтой ба үүний жишээ нь Канад улсын Ванкувер хотод 2017 онд дэлхийн хамгийн өндөр модон барилга болох 53м өндөртэй 18 давхар модон барилгыг барьсан байна.

“Модон бүтээц” барилгын норм ба дүрэм /БНбД 54-01-07/ нь 2007 онд боловсруулагдан өнөөг хүртэл хэрэглэгдэж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд манай улсад модон барилгын салбар эрчимтэй хөгжиж байгаатай уялдан Олон улсын жишигт нийцсэн модон барилгын норм, дүрэмтэй болох зайлшгүй шаардлага гарч байна. Иймд ОХУ-ын Европын холбооны хэм хэмжээтэй нийцүүлэн гаргасан СП-64.13330.2017: “СНИП II-25-80 Деревянные конструкции” баримт бичгийг өөрийн үндэсний хэл дээр хөрвүүлж өөрийн орны онцлог, цаг уурын нөхцөл зэргийг тусган шинэчлэн боловсруулахаар техникийн даалгаварыг боловсруулаад байна.

Барилгын байгууламжийн норм, нормативын сангийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан энэ ажлын техникийн даалгаврын онцгой нөхцөлд “Салбарт мөрдөгдөж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийн үг хэллэг, утга агуулгатай уялдаж нийцсэн байх”, олон улсын баримт бичгийн өнөөгийн жишигт нийцсэн байхаар боловсруулах шаардлагыг тусгаж өгсөн болно.

БАТЛАВ.
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Сүм Ц.МАГНАЙСҮРЭН

“МОДОН БАРИЛГЫН ЗУРАГ, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨЛТ. ЕРӨНХИЙ ДҮРЭМ” /БД/-ИЙГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2018 оны 8. дугаар
сарын 08-ний өдөр

Дугаар 20/2018

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	1. “Барилгын тухай хууль” – ийн 34.1.2 дугаар заалт; 2. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”; 3. “Барилгын байгууламжийн норм, нормативын сан”-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.
2	Төслөөр шийдвэрлэх асуудлууд	Энэхүү барилгын норм, дүрмийг боловсруулсанаар олон улсын жишигт нийцсэн Мод, модон бүтээцтэй /хөрөөдсөн, харуулдсан, наамал мод болон модон бүтээцтэй бүтээгдэхүүн г.м/ барилгын үндсэн төлөвлөлт, аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал болон зарчмын шаардлагуудыг тусгасан ногоон хөгжлийг дэмжсэн барилгын дүрэмтэй болно.
3	Төслийн бүрдэл	Агуулга 1. Хамрах хүрээ 2. Норматив ишлэл 3. Нэр томъёо ба тодорхойлолт 4. Ерөнхий зүйл 5. Материал 6. Материалын тооцооны үзүүлэлт 7. Модон бүтээцийн элементүүдийн 1-р бүлгийн хязгаарын төлөв байдлын тооцоо - Төвийн суналт ба төвийн шахалтын элементүүд - Гулзайлтын элементүүд - Тэнхлэгийн хүч болон гулзайлтын хүч хосолсон элементүүд - Модон бүтээцийн элементүүдийн тооцооны урт ба хязгаарын уян чанар - Фанер, мод хосолсон наамал элементүүдийн тооцооны онцлог - Модон бүтээцийн элементүүдийн 2-р бүлгийн хязгаарын төлөв байдлын тооцоо 8. Модон бүтээцийн элементийн холбоосны тооцоо - Ерөнхий аргачлал - Цавуун холбоос - Заадалт холбоос - Тээгэн/нагель/ холбоос - Таталтанд ажиллах хадаас шурган холбоос - Пластик тээгэн/нагель/ холбоос - Наамал шилбэн холбоос 9. Модон бүтээцийн төлөвлөлтийн аргачлал

		Ерөнхий заалт - Гол нуруу, сараалж, дэвсгэр банз - Нийлмэл дам нуруу - Наамал модон дам нуруу - Татанга - Арк ба Свод - Хүрээ - Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурууд - Мод болон модон бүтээцийн хийцийн бат бөхийн шаардлагууд 10. Модон бүтээцийн галын техникийн шаардлага - Гал тэсвэрлэх хязгаар - Галын эрсдлийн байгуулалт - Галын хамгаалалтын бүрэлдэхүүн Хавсралт А - Наамал модны ангилал Хавсралт Б - Модны чанарын нэмэлт шаардлагууд Хавсралт В - Нарс, гацуур, наамал модон элемент болон нэг чиглэлтэй наамал модон хавтангын физик-механик шинж чанар Хавсралт Г - Мод болон модон материалын нягт Хавсралт Д - Дам нурууны фанеран хана ба хавтангийн тооцооны график Хавсралт Е - Шахалт болон гулзайлтад ажиллаж байгаа элементүүдийн тооцооны өгөгдлүүд Хавсралт Ж - Наамал шилбэ Хавсралт И - Наамал модон дам нурууны тулгуурын хэсгүүдийн үндсэн талбайгаар бат бэхийн тооцоо хийх Хавсралт К – Шүдэт металл хавтан холбоос бүхий татангын загварын онцлог шинж чанар Хавсралт Л - Наамал анкер бүхий дам нурууны тооцоо Хавсралт М - Наамал холбоос бүхий нуман рамны загварын онцог Хавсралт Н - Модон бүтээцийг хамгаалах бүтээцийн арга хэмжээ Хавсралт П - Шураг болон глухар/ болтон толгой бүхий шураг/-ын шинж чанар Хавсралт Р - Үсгэн тэмдэглэгээ тэдгээрийн тодорхойлолт
4	Төслийн үр дүн	Олон Улсын жишигт нийцсэн модон барилгын үндсэн бүтээц төлөвлөлт, баталгаажуулалт, ашиглалтын хугацаа, аюулгүй байдал зэрэг зарчимын шаардлагуудыг тодорхойлох ач холбогдол бүхий барилгын дүрэмтэй болно.
5	Төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд	Барилгын хөгжлийн төв
6	Төслийн гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулна.
7	Төслийн боловсруулж дуусгах хугацаа	2019 оны 1-р улирал

8	Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ	Эх үүсвэр нь “Барилга байгууламжийн норм, нормативын сан”.
9	Онцгой нөхцөл	✓ СП-64.13330.2017: “СНИП II-25-80 Деревянные конструкции” ✓ Eurocode 5: Design of timber structures - Part 1-1: General - Common rules and rules for buildings /Модон барилгын зураг, төсөл төлөвлөлт. Ерөнхий дүрэм/ ✓ Eurocode 5: Design of timber structures - Part 1-2: General - Structural fire design /Модон барилгын зураг төсөл төлөвлөлт. Бүтээцийн галын хэсэг/ ✓ Олон улсын баримт бичгийн өнөөгийн жишиг нийцсэн байх ✓ Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 74 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”-ны шаардлагыг хангасан байх бөгөөд бусад норматив баримт бичигтэй зөрчилдөхгүй байна. ✓ Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ төрлийн нормативын баримт бичгийн үг хэллэг, утга агуулгатай уялдаж нийцсэн байх. ✓ Боловсруулагдаж байгаа баримт бичгийн төсөл нь техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй, нэмэлт мэдээлэл тусгагдахаар сайжруулалт хийх тохиолдолд захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.